

“СҮХБААТАР” НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН 2025 ОНЫ 05 САРЫН БАЙДЛААР  
ЭРХ ЗҮЙН АЖЛЫН ТАЙЛАН

№	Хуулийн заалт	Заалтын хэсэг	Биелэлт
I.	Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт /шинэчилсэн найруулга/		
1.	5 бүлэг. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа	41 зүйл. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүсэх	<p>СБНЭ-ийн даргын 2021 оны 12 сарын 15-ны өдрийн А/162 дугаар “Хөдөлмөрийн гэрээ шинэчлэн батлах тухай” тушаалаар Монгол улсын Засгийн газрын 2021 оны 07 сарын 02-ны өдөр батлагдсан “Хөдөлмөрийн тухай /Шинэчилсэн найруулга/” хуулийн дагуу хөдөлмөрийн гэрээг шинэчилсэн.</p> <p>2025 онд шинээр орж байгаа ажилчидтай ба хүүхэд асрах чөлөөнөөс орж ирж байгаа үндсэн ажилчдын хөдөлмөрийн гэрээг шинэ загварын алгуу байгуулан ажиллаж байна. Хөдөлмөрийн гэрээ болон Албан тушаалын тодорхойлолтыг тус бүр 2% үйлдэж 1%-ийг ажилтанд гарын үсэг зуруулан тус тус олгон ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт байгуулахаас гадна Нэгдсэн эмнэлгийн захирлын тушаалар баталгаажна.</p>
2.	42 зүйл. Ажилтны үндсэн эрх	42.1.1. Ажил олгогчтой сайн дурын үндсэн дээр хөдөлмөрийн гэрээ байгуулах, өөрчлөх, цуцлах.	<p>Нэгдсэн эмнэлэг нь ажилчдыг сонгон шалгаруулах журмын дагуу шинэ ажилчдыг шалгаруулан авдаг. Ажил горилогчдыг анкет бөглүүлж, бүрдүүлэх материалын жагсаалтыг өгч тухайн албан тушаалд сул орон тоо гарсан үед ярилцлаганд ордог ба шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн шалгалт өгдөг. Ажилтныг туршилтын хугацаа 3 сар байна. Энэ хугацаа ажилтан болон ажил олгогч бие биенээ таних, хамтран ажиллах арга барилаа олох хугацаа. 2025 оны эхний 5 сарын байдлаар нийт 22 хүн шинээр ажилд орсон байна. Хөдөлмөрийн гэрээг цуцалсан 30, тэтгэвэрт 1, жирэмсний болон хүүхдэд асрах чөлөө авсан 0 хүн, нийт ажлаас чөлөөлөгдсөн 31 хүн байна. Ажилд орох хүсэлт гаргасан мэргэжилтний бүртгэлийн сан байгуулж, шаардлагатай үед дуудаж, ярилцлага хийх зэрэг журмын дагуу шаардлагад нийцэж байгаа шалгуур хангасан ажилчдыг сонгон шалгаруулалтаар ажилд авдаг. Эрүүл мэндийн салбарт нөөц багатай эмнэлгийн мэргэжилтнийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр зарлаж авдаг.</p>

			Ажилтан сайн дурын үндсэн дээр хөдөлмөрийн гэрээ байгуулах, өөрчлөх, цуцлан ажиллаж байна.
		42.1.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартад нийцсэн ажлын байранд ажиллах, энэ талаар бодит мэдээлэл авах.	

	<p>42.1.3. Гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин авах</p>	<p>Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Журам батлах тухай” 382 дугаар тогтоол, 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 02 сарын 28-ны өдрийн “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 84 дүгээр тогтоол, 2024 оны 03 сарын 27-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол, тогтоолын дагуу, 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Журам батлах тухай” 5 дугаар тогтоол, 2020 оны 04 сарын 29-ний өдрийн “Тогтоолын хавсралтанд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 151 дүгээр тогтоол, 2017 оны 09 сарын 03-ны өдрийн “Журам батлах тухай” 246 дугаар тогтоолын “Төрийн болон нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох тухай” 4 дүгээр хавсралт, 2022 оны 12 сарын 28-ны өдрийн “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491 дүгээр тогтоол; Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 05 сарын 03-ны өдрийн “Тэтгэвэрийг хөнгөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 77 дугаар тушаал; Эрүүл мэндийн сайдын 2018 оны 12 сарын 28-ны өдрийн “Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын хоол, унааны хөнгөлөлт, нэмэгдэл, урамшлын хэмжээг тогтоох тухай” А/548 дугаар тушаал, 2017 оны “Дүрэм батлах тухай” А/256 дугаар тушаалын “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хорооны журам” 3 дугаар хавсралтын 6.3 дугаар заалт, 2020 оны А/69 дүгээр “Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах тухай” тушаал; “Сүхбаатар” Нэгдсэн эмнэлгийн Удирдлагын багийн 2024 хурлын тэмдэглэлүүд, “Нэгдсэн эмнэлгийн дотоод журмын 3 зүйлийн 3.2 заалтыг тус тус үндэслэн цалин хөлс, урамшууллын механизмыг мөрдөн ажиллаж байна.</p> <p>Нэгдсэн Эмнэлэг нь хоол, унаа, хэвийн бус нөхцөл, хүүхдийн тасгийн нэмэгдэл, эрчимт эмчилгээний эмчийн нэмэгдэл, ёс зүйн хэсгийн хорооны, нууцын, хариуцлагын, ур чадвар, үр дүнгийн нэмэгдлүүдийг өгч байна.</p>
--	--	--

			Нэгдсэн Эмнэлэг нь хоол, унаа, хэвийн бус нөхцөл, хүүхдийн тасгийн нэмэгдэл, эрчимт эмчилгээний эмчийн нэмэгдэл, ёс зүйн хэсгийн хорооны, нууцын, хариуцлагын, ур чадвар, үр дүнгийн нэмэгдлүүдийг өгч байна.
		42.1.4. Ээлжийн амралт эдлэх, зохих журмын дагуу хувийн чөлөө авах	Жил бүрийн эхэнд ээлжийн амралтын саналыг нийт ажилчдаас аван зохицуулалт хийж, хуваарийн дагуу ээлжийн амралт олгодог. Ажилчдын саналын дагуу ээлжийн амралтыг хэсэгчилэн болон бүтнээр эдлүүлдэг. 2025 оны эхний 05 сарын байдлаар нийт 71 ажилтан ээлжийн амралтаа бүрэн эдэлсэн байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 100 дугаар зүйл, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалт, Амралт чөлөө олгох журмын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтуудын дагуу 2025 оны эхний 5 сарын байдлаар давхардсан тоогоор 73 хүн 352 өдрийн чөлөө авсан байна.
		42.1.5. Хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн гэж үзвэл эрх бүхий этгээдэд гомдол гаргах.	2025 онд Хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн тухай ажилчдаас өргөдөл, гомдол, санал ирээгүй болно.
		42.1.6. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, баталгаажилтанд хяналт тавих, буруу, дутуу бичилт, алдааг залруулахыг шаардах	2025 оны Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, баталгаажилтанд хяналт тавих, буруу, дутуу бичилт, алдааг залруулахыг шаардахтай холбоотой ажилчдаас өргөдөл, гомдол, санал ирээгүй болно. Байгууллагын зүгээс Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, баталгаажилт хэвийн байна.
		42.1.7. Хууль тогтоомжинд заасан бусад эрх	“Сүхбаатар” Нэгдсэн эмнэлэг нь ажилчдын ажиллах нөхцлийг бүрдүүлэх, цалин хөлс, нэмэгдлүүд, ээлжийн амралт, чөлөө тэтгэмж, шагнал уруумшуулыг цаг алдалгүй олгож, шийдвэрлэн ажилладаг. Ажилчдын сэтгэл ханамж 93.35% байна.
		43.2.9. Ажилтныг хууль тогтоомжинд заасны дагуу ажлын байрны чиг үүрэгт хамаарах чиглэлээр мэргэжлээ дээшлүүлэх, давтан сургах боломжоор хангах	<ul style="list-style-type: none"> <li>• ЗГ-ын 224 тоот тогтоолын дагуу ЭМБО сургалтын график гарган сургалт зохион байгуулан улирал бүр төлөвлөгөөний хэрэгжилтэнд дүгнэлт өгч ажиллаж байна.</li> <li>• 2025 оны 05 сарын 01-ний байдлаар дараахи сургалтуудад хамрагдсан:</li> </ul>

№	Сургалтын төрөл	2025 оны эхний 05 сарын байдлаар байгууллагын ажилчдад явуулсан	
		Сургалтын тоо	Суусан хүний тоо
1	Ёс зүй	54	1504
2	Харилцаа хандлага	45	1501
3	Хууль эрх зүй	51	2102
4	Эрүүл аж төрөх зан үйл	52	1810
5	Тусламж үйлчилгээ	86	2871
6	Халдварын сэргийлэлт	140	3443
7	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй	50	2633
8	Бусад	37	1665
Нийт		<b>970</b>	<b>515</b>

2025 оны байдлаар төрөлжсөн мэргэжил эзэмшсэн эмч 3, сувилагч 7 суралцаж байна. Үндсэн мэргэшлийн сургалтад 13 эмч суралцаж байна. Магистрын сургалтанд эмч 2, сувилагч 3 суралцаж байна. Сувилагчийн ангид 11 хүн сурч байна. Эмчийн ангид 3 сувилагч суралцаж байна.

Байгууллага нь ажилтан бүрийн ойрын болон дунд хугацаанд өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний дагуу ур чадвар, туршлагыг үнэлж, тэднийг сургах, хөгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөг жил бүр гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Жил бүрийн 1 сард ажилчдын сургалтын хэрэгцээний судалгааг аван, нэгтгэн ажиллаж байна. 2025 оны эхний 5 сарын байдлаар нийт ажилчид 100% буюу 1 ажилчин дунджаар 5-6 удаа дотоодын сургалтанд хамрагдсан.

Гадаад сургалтанд 2 хүн суралцаж, 1 эмч хамрагдаж байна.

2025 онд дотоод сургалтанд нийт давхардсан тоогоор 496 ажилчин, албан хаагч, 220 өдрийн сургалтанд хамрагдсан байна. Үүнээс: эмч – 269, сувилагч

			<p>– 121, эмнэлгийн тусгай мэргэжилтэн – 13, асрагч – 33, удирдах ажилтан – 55 хамрагдсан байна.</p> <p>Байгууллагын сургалтанд 17529 ажилтан, 515 өдрийн сургалтанд хамрагдсан байна. Үүнээс: давхардсан тоогоор эмч – 4018, сувилагч, тусгай мэргэжилтэн – 10538, асрагч – 2667, бусад – 306 байна.</p>												
		<p>5.3. Ажил олгогч нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.</p>	<p>“Сүхбаатар” Нэгдсэн эмнэлэгт ажиллаж байгаа нийт ажилчдын 221 эмэгтэй ажигчинтай ба 76,2% нь эмэгтэйчүүд. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчмын дагуу эрэгтэй эмэгтэй хүн бүрийг эрх тэгш байдлыг ханган нийгмийн амьдралд оролцох бололцоогоор ханган ажиллаж байна. Мөн жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглох зүйлүүдийг, эрэгтэй эмэгтэй хүний тэгш эрхийг хангах тусгай арга хэмжээнүүдийг ажилдаа авч хэрэгжүүлж байна.</p> <p>“11.2” заалтын дагуу цалин олголт тэгш явагддаг ба ажилчдын нөхцөл нь ижил байна.</p> <p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 13 зүйлийг үндэслэн СБНЭ-ийн даргын 2024 оны 06 сард Урьдчилан сэргийлэх үзлэгт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 14 зүйлийг үндэслэн нийт гэр бүл болж байгаа ажилтнуудыг дэмжин ажиллаж байна.</p>												
4	<p>Наймдугаар бүлэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд</p>	<p>120.1. Ажил олгогч нь ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр дүнтэй, шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.</p>	<p>Эрүүл мэндийн, Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яамнаас тогтоосон норм нормативыг үндэс болгон ажиллаж байна.</p> <p>Жил бүр ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан ажиллаж байна. 2025 оны хувьд 6 сард эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Эрүүл мэндийн чиглэлээр дараах ажлуудыг хийсэн:</p> <table border="1" data-bbox="1039 1031 1885 1318"> <thead> <tr> <th>№</th> <th>Байгууллага</th> <th>Хугацаа</th> <th></th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1.</td> <td>Ахмад настны үзлэг зохион байгуулах</td> <td>2025.02.05-2025.03.31</td> <td>ЭЭОД ҮАЭОД ДА</td> </tr> <tr> <td>2.</td> <td>Улаанбурхан өвчний эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалтанд хамруулах</td> <td>2025.03.31</td> <td>ХСХА ХНА</td> </tr> </tbody> </table>	№	Байгууллага	Хугацаа		1.	Ахмад настны үзлэг зохион байгуулах	2025.02.05-2025.03.31	ЭЭОД ҮАЭОД ДА	2.	Улаанбурхан өвчний эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалтанд хамруулах	2025.03.31	ХСХА ХНА
№	Байгууллага	Хугацаа													
1.	Ахмад настны үзлэг зохион байгуулах	2025.02.05-2025.03.31	ЭЭОД ҮАЭОД ДА												
2.	Улаанбурхан өвчний эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалтанд хамруулах	2025.03.31	ХСХА ХНА												

3.	Нэгдсэн эмнэлгийн ажилчдын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах тухай	2025.04.24	ХНА
4.	Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах, эрүүл мэндийн үзлэгт оруулах, эрүүлжүүлэх ажил зохион явуулах	2025.06.05- 2025.06.19	ХНА Дотрын эмч- Ажилтны эрүүл мэнд хариуцсан эмч
5.	Ажилчдын эрүүл мэндийг дэмжих 6 сарын аян	2025.01.01- 2025.06.01 /5 сар/	
6.	Дархлаажуулалтын аян	2025.02.15- 2025.03.15	

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар хийсэн ажлууд:


1. Байгууллагын даргын тушаалаар тасаг бүрт ХАБЭА-ийн ажилтан шинээр томилж, ХАБЭА-н сургалтанд 6 хүн сургахаар төлөвлөн ажиллаж байна.
2. “Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх болзошгүй осол гэмтлийн үед үзүүлэх анхны тусламжийн сургалт”- д хамрагдсан.
3. Байгууллагын эмч мэргэжилтнүүдэд доорхи чиглэлээр сургалт явуулсан:
  - Хөдөлмөрийн харилцааны суурь, зарчмын талаарх ойлголт, ХАБЭА-ын шаардлага, стандарт
  - Хөдөлмөрийн тухай хууль
  - MNS 4969:2000 Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуйн Зааварчилгаа
  - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

**Сургалтанл хамрагдсан байдал:**

Сургалт	Эмч	Сувилагч	Асрагч	Бусад	Нийт
ХАБЭА	445	969	251	0	<b>1665</b>

4. Шинээр ажилд орж байгаа ажилтанд ажлын байран дахь анхан шатны буюу урьдчилсан зааварчилгааг нийт 22 хүнд өгсөн.
5. Насанд хүрэгсдийн сэхээний нийт 25 эмч, сувилагч, асрагч нарт хүчилтөрөгчийн баллон, дефибрилятор, дуслын шахуургаар сургалт хийсэн байна.
6. “Хөдөлмөрийн аюулгүй байдал - эрүүл мэндийн хөгжил: ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ХЭРЭГЛЭЭ БА ЦАХИМЖИЛТ” уриан дор 04 сарын 25-аас 1 сарын аян зохион байгуулсан. Үүний дагуу байгууллагын Даргын 2025 оны 04 сарын 25-ны өдрийн А/62 тоот тушаал гарсан. Нийт 7 тасаг, нэгж хамрагдсан.
7. Байгууллагын эмч ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгийг 2025.06.05-2025.06.25-ны дотор зохион байгуулахаар хуваарь гарч, үзлэгийн дараа шинээр оношлогдсон архаг хурц өвчтэй, ажилтан бүрт эрүүлжүүлэх төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
8. “Хиймэл оюун ухааны тухай ойлголт сэдвээр” Мэдээллийн технологийн албаны дарга 126 эмч ажилчдад сургалт явуулсан.
9. “Би байгууллагын нэг хэсэг” сургалтанд нийт 55 хүн хамрагдаж, аюулгүй ажиллагааны анхан шатны мэдлэг, чадваржуулах сургалтанд хамрагдсан.
10. Байгууллагын 2025 оны аппарат тоног төхөөрөмжийн судалгааг Инженер тоног төхөөрөмжийн албаны дарга, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер тухай бүрт нь хийн ажиллаж байна.

		120.2. Ажил олгогч ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт хангасан хөдөлмөрийн хэвийн нөхцлөөр хангах эрхтэй.	Ажил олгогч ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт хангасан хөдөлмөрийн хэвийн нөхцлөөр ханган ажиллаж байна. 2025 онд ажилчдын хувцсанд 15'6210'255 төгрөг, хөдөлмөрийн хэрэгсэлд 58'105'127 төгрөг тус тус зарцуулсан байна.
		120.3. Ажил олгогч ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийг хэвийн болгох хүртэл хугацаанд ажилтны ажлын цагийг богиносгох, нэмэгдэл амралт, хэвийн бус нөхцөлд ажилласны нэмэгдэл олгох зэрэг шаардлагатай түр арга хэмжээг хууль тогтоомжинд нийцүүлэн авна	Нэгдсэн эмнэлэгт хэвийн бус нөхцөлд 76 ажилтан ажиллаж байгаа бөгөөд хэвийн бус нөхцлийн нэмэгдэл үндсэн цалингийн 10%-ийг сар бүрийн цалин дээр олгон ажиллаж байна. Хортой нөхцөлд ажиллаж байгаа 2 ажилтны ажлын цагийг 1 цагаар хорогдуулж, сүү олгон ажиллаж байна.
		120.4 Ажилтан ажил үүргээ гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтоомж, шаардлага, стандартыг мөрдөж ажиллах үүрэгтэй	Ажилтан ажил үүргээ гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтоомж, шаардлага, стандартыг мөрдөж ажиллаж байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтоомж, шаардлага, стандартыг хангуулан ажиллуулах үүднээс анхан болон давтан зааварчилгаануудыг цаг тухай бүрт нь өгч ажилладаг.

	<p>120.5. Ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах талаар ажил олгогчоос тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.</p>	<p>Шинээр ажилд орж байгаа болон ажлын байраа өөрчилсөн ажилчдад танилцуулах “Бяцхан хөтөч № 1”, “Бяцхан хөтөч № 2”, “Бяцхан хөтөч № 3” 2025 оны хувьд шинэчлэн хэвлэн гаргасан.</p>  <p>Уг номуудыг уншуулан танилцуулж, тухайн ажилтны ажиллах ажлын байрны онцлог, зохион байгуулалт зэргээр зааварчилгаа өгдөг. Уг номуудыг уншуулан танилцуулж, тухайн ажилтны ажиллах ажлын байрны онцлог, зохион байгуулалт зэргээр зааварчилгаа өгдөг.</p> <p>Дадлага хийхээр ирж буй 54 оюутанд зааварчилгаа өгч, Нэгдсэн эмнэлэг, ажлын байрны талаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар тодорхой ойлголттой болон ажиллаж байна. Ажлын байрны зүг чиг, баримжаагаа түргэн олоход нь туслах үүднээс эмч – шинээр орсон эмч, сувилагч - шинээр орсон сувилагчтай багш-шавийн барилдлагатай ажиллаж өөрийн дадлага туршлага, ажлын зөвлөх нь болон ажилуулж байна. Шинээр орсон ажилчдад, дадлага хийх гэж байгаа оюутнууд тус бүрт анхан шатны зааварчилгаа өгөн ажиллаж байна. 2025 онд анхан шатны зааварчилгаа авсан 22 ажилтан, давтан зааварчилгаа авсан 290 ажилчин байна.</p>
	<p>121.1. Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, эрүүл, аюулгүй</p>	<p>➢ СБНЭ-ийн Хөдөлмөрийн дотоод журмын 3.16 дугаар заалт, Ажилчин албан хаагчдын ажиллах нөхцөл, Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 5.5.2 дахь заалтын дагуу Нэгдсэн эмнэлэгт хэвтсэн тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын хураамж 15%-ийн төлбөрийг байгуулагаас хөнгөлдөг. 2025 оны эхний 05 сарын 30-ны байдлаар давхардсан тоогоор нийт 108 ажилчин, ажилчдын ар гэрийн 76 хүмүүст хэвтэн эмчлүүлэхэд Эрүүл мэндийн даатгалын төлбөрийн 15%-ийн хөнгөлөлт үзүүлсэн байна.</p>

		орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар зохицуулна.	Бусад эрүүл мэндийн байгууллагын 12 ажилтанд болон эрүүл мэндийн салбарын 21 ахмад настанд эмнэлгийн тусламж үйлчилгээг очер дэс дараалалгүй, хөнгөлөлттэй, шинжилгээг нь тухай бүрт хийж хэвтүүлэн эмчилсэн.
5	6 дугаар зүйл. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, гадуурхахыг хориглох	6.1. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүний үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэлтийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно.	Нэгдсэн эмнэлэг нь нийт ажилчидтайгаа тэгш харьцан ажилладаг. Үүнд хүний үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэлтийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд эсхүл шууд бусаар нь ялгаварлах бодлого явагддаггүй. Нийт ажилчдын хамт олныг эвтэй, багаар үр дүнтэй ажиллуулах үүднээс жилийн турш 23 аян өдөрлөг, 2 спорт тэмцээн зохион явуулсан.  2025 онд 35 ажилтаныг үзвэрийн билетээр урамшуулан ажилласан:

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:  
ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ,  
ГАДААД ХАРИЛЦААНЫ АЛБАНЫ ДАРГА

Д.ЭНХЭЭ

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:

ЗАХИРАЛ

Б.БАТЧИМЭГ